



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын сэдэв: Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр нөлөө

Аудитын гол дүгнэлт: - Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төслийн 29.4 хувь нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа бол бусад төслийн хувьд чанаргүй гүйцэтгэсэн, төрийн байгууллага хуульд заасан шалгуур хангаагүй зээл авсан, хяналтгүй байгаагаас зарим төслийн үр өгөөж үр дүнгүй байна.

Тайланг хүргүүлсэн этгээд:

Аудитын тайланг Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор А.Ариунбаяр

Утас: 99076224 Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор Б.Ариунзул

Утас: 89133344 Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор А.Мөнхцэцэг

Утас: 99784578 Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Баруун-Урт 2023 он

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн “Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил”, БНБУ-ын Засгийн газрын “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”, Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн зээл НАМЭМ, Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янзын байдлын хамгаалал; Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төсөл болон ХААДС-аар олгосон БНХАУ-ын зээлийн 2016-2022 оны үйл ажиллагаа хамрагдлаа
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ын боловсруулсан Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит –Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах болон судалгааг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглалаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын талбарын ажлыг 2023 оны 6 сарын 02-ны өдрөөс 2023 оны 7 сарын 01-ны өдөр хүртэл гүйцэтгэж, тайланг 2023 оны 8 сарын 09-ний өдрийн дотор танилцуулж, баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.
Хүндрэл бэрхшээл	Хэрэгжиж буй төслийн нэгдсэн мэдээлэл орон нутагт байхгүй байгаагаас аудитын талбарын үе шатны ажлыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байв.

БҮЛЭГ 1. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төслийн 29.4 хувь нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа бол бусад төслийн хувьд чанаргүй гүйцэтгэсэн, төрийн байгууллага хуульд заасан шалгуур хангаагүй зээл авсан, хяналтгүй байгаагаас зарим төслийн үр өгөөж үр дүнгүй байна.

А.1 Хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр хэрэгжүүлсэн зээл, төсөл арга хэмжээ нь хөгжлийн бодлоготой нийцэж байгаа боловч шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн тодорхойгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлогыг дараах байдлаар тодорхойлжээ.

- Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ;
- I үе шат (2021-2030): Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих үе;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;
- Уг тэргүүлэх зорилтын хүрээнд хөдөө аж ахуйн салбарт 142 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд 58 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн

Төслийн зорилго нь хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсөл арга хэмжээний зорилттой нийцэж байгаа боловч төслийн хүрэх үр дүнг тодорхой тусгаагүй байна.

Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа гадаадын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжиж байгаа төслөөс Сүхбаатар аймагт дараах төслүүд хэрэгжжээ. Үүнд:

- *НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн “Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил” хөнгөлөлттэй зээл,*
- *БНБУ-ын Засгийн газрын “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” экспортын зээл,*
- *Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл*

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж төслийн сонгон шалгаруулалтын процесс ХХААЯ-д явагдаж байгаа тул орон нутгийн түвшинд дүгнэлт гаргах боломжгүй байна.

А.2 Орон нутгийн төсвийн байгууллага аймгийн ИТХ-ын зөвшөөрөлгүйгээр төслийн зээлд хамрагджээ

Аймгийн хэмжээнд БНХАУ-ын Засгийн газрын зээлийн эх үүсвэрээр Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан 2016-2022 онд 128.7 сая төгрөгийг 4 иргэн, аж ахуйн нэгж, төсвийн байгууллагад олгосон байна.

Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн эх үүсвэрээр Төрийн, ХААН банкаар дамжуулан 74 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 1,171.0 сая төгрөгийн зээл олгосон

байна. Уг төслийн зээлийг олгоход тусгай шалгуур тавиагүй бөгөөд жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид тухайн банкны шалгуурт нийцүүлэн олгосон байна.

Мөн Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтийн эх үүсвэрээр ЖДҮДС-аар дамжуулан 2021 онд дараах 2 хоршоонд 174.0 сая төгрөгийн зээл олгожээ.

Төслийн хүрээнд олгосон нийт зээлээс хүнс, хөдөө аж ахуйн зориулалтаар 34 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 846.4 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Зээлийн зориулалтыг төрөл тус бүрээр дурдвал:

1. Хадлан, тэжээл бэлтгэх зориулалтаар 6 иргэн, аж ахуйн нэгжид 165.0 сая;
2. Хүнсний ногоо, газар тариалангийн зориулалтаар 9 иргэн, аж ахуйн нэгжид 149.0 сая;
3. Мал мах бэлтгэх, фермерийн зориулалтаар 6 иргэн, аж ахуйн нэгжид 340.5 сая;
4. Сүү, цагаан идээ боловсруулах зориулалтаар 2 иргэнд 15.4 сая;
5. Хөдөө аж ахуйн тоноглол, арьс шир элдэх зориулалтаар 3 иргэнд 17.0 сая;
6. Хүнс, хоол үйлдвэрлэлийн зориулалтаар 8 иргэнд 159.5 сая төгрөг;

Хөдөө аж ахуйн зориулалтаар төслийн зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний үүргийн биелэлтийг авч үзвэл:

- Баяндэлгэр сум: 6 иргэн, аж ахуйн нэгж 103.5 сая төгрөгийн зээлд хамрагдсанаас хадлан тэжээл бэлтгэх, арьс нэхий элдэх зориулалтаар авсан 2 төсөл буюу 33.4 хувь нь зориулалтын дагуу ашиглагдаж байна.
- Түвшинширээ сум: 6 иргэн, аж ахуйн нэгж 25.0 сая төгрөгийн зээлд хамрагдсанаас хүнсний ногоо тариалах 2 төсөл буюу 33.4 хувь нь зориулалтын дагуу хэрэгжиж байгаа
- Эрдэнэцагаан сум: 16 иргэн, аж ахуйн нэгж 475.9 сая төгрөгийн зээлд хамрагдаж 6 төсөл буюу 47.5 хувь нь зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.
- Сүхбаатар, Мөнххаан сумын 6 зээлдэгчийн гэрээний үүргийн хэрэгжилт ямар түвшинд байгаа нь тодорхойгүй, мэдээлэл хангалтгүй байна.

Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөр зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дийлэнх нь зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байна. Эндээс дүгнэж үзвэл үндсэн зорилтын хэрэгжилт хангагдаагүй, төслөөс бий болох үр өгөөж хангалтгүй, үр дүнд хүрээгүй байна.

Уг төслийн санхүүжилтээр ЖДҮДС-аас дамжуулан зээлд хамрагдсан Ашид мөнх баян хоршоо, Мөнгөн саам хоршоодын эргэн төлөлт хугацаа хэтэрсэн ангилалд орсон байна.

Хоёр: Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газраас авсан "Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл"-ийн хүрээнд Онгон сумын ЗДТГ 2021 онд техник тоног төхөөрөмжийг зээлээр худалдан авсан байна. Онгон сумын ЗДТГ 2022 онд уг трактор, техник, тоног төхөөрөмжийг өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах зорилгоор сумын иргэнд ашиглуулж, сумын өвсний нөөцөд 5,000 боодол өвс авсан байна. Иргэнд техник тоног төхөөрөмжийг ашиглуулахдаа гэрээ байгуулаагүй, нөөцийн өвс бэлтгэх зардлыг төсөвт тусгаагүй, хадсан өвсийг худалдан борлуулж зарцуулсан байна. Өвсний орлого, зарлагыг тооцож нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹, 13.4², 14 дүгээр зүйлийн 14.3.1³, 14 дүгээр зүйлийн 14.4⁴-т заасныг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

¹ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

² Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

³ анхан шатны баримт бүрдүүлэх;

⁴ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

Гурав: Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслөөс /ЖАЙКА/ 3 аж ахуйн нэгж, байгууллага 400.0 сая төгрөгийн зээл авсан боловч тус зээл хөдөө аж ахуйн зориулалтаар бус үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгогдсон байна.

Дөрөв: “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөр Баруун-Урт, Дарьганга, Сүхбаатар сумын 15 иргэн, 3 аж ахуйн нэгжид 61.1 сая төгрөгийн өртөгтэй сүү, цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Мөн төслийн хөрөнгөөр аймгийн 7 суманд инженерийн хийцтэй гүн өрмийн 8 худгийг 191.2 сая төгрөгөөр гаргаж орон нутгийн төр захиргааны байгууллагад хүлээлгэн өгчээ.

Төсөлд хамрагдсан 15 иргэн сүү, цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмжийг өрхийн хэрэгцээнд ашиглаж байгаа бол Сүхбаатар Сүү ХХК-д олгосон тоног төхөөрөмжийг орон нутгийн зээлийн барьцаанд тавьсан байна. Тоног төхөөрөмжийг зээлийн барьцаанд тавьж байгаа нь үндсэн зорилтын хэрэгжилт болох ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, хөдөөгийн хөгжлийг дэмжих чиг үүргийн хүрээнд эрсдэл үүсгэж байна.

Тав: Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох, Экспортыг дэмжих төслийн хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлд Сүхбаатар аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж хамрагдаагүй байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны “Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 110 дугаар тогтоолоор Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хөрөнгөөс малчин өрх бүрд 0.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх талаар тусгасан боловч Сүхбаатар аймгийн малчин өрхөд уг дэмжлэг олгогдоогүй байна.

Зарим төсөл арга хэмжээг ажлын тоо хэмжээнээс багаар гүйцэтгэн, чанаргүй болгосон нь төслийн үр өгөөж буурахад нөлөөлсөн байна.

Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийг Баруун-Урт, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан суманд хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан байна. Гэвч уг төслийн санхүүжилтээр 2018-2022 онд 13 суманд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна.

д/д	Хөрөнгө оруулалтын ажлын нэр	Тоо хэмжээ	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	Өвсний саравч, хашаа, тэжээлийн агуулах	10	1,197.0
2	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг	16	432.0
3	Бог малын угаалгын ванн	17	240.0
4	Бод малын үйлчилгээний зогсоол	13	65.0
5	Оготно устгалын тоног төхөөрөмж	18	13.9
6	Малчдын мэдээллийн танхим	3	30.0
7	Ажлын байрны засвар	1	30.0
НИЙТ ДҮН		78	2,007.9

Зарим сумдад баригдсан өвсний саравч, хашаа, тэжээлийн агуулахыг жишиг ажлын зураг, төсөвтэй тулган баталгаажуулахад ажлыг чанаргүй гүйцэтгэсэн байна. Тухайлбал.

- Түвшинширээ сумын өвс, тэжээлийн агуулахын гадна хашааг “Голден Август” ХХК ажлын зураг, техникийн тодорхойлолтод заасан хэмжээнээс дутуу барьсан байна.
- “Сагсай Өргөө” ХХК-ний гүйцэтгэсэн Баруун-Урт суманд баригдсан өвсний саравч, тэжээлийн агуулахын гадна хашаа нурсан, Баяндэлгэр суманд баригдсан тэжээлийн агуулахын дээвэр салхинд хийсэж нурсан, тулгуур баганыг зурагт

заасны дагуу газар ухаж суулгаагүй, шууд газар дээр байрлуулсан нь нурахад нөлөөлсөн байна.

“Том Ноёд” ХХК Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан суманд 48.0 сая төгрөгийн өртөгтэй бог малын угаалгын 6 ванныг барьж хүлээлгэсэн өгсөн байна.

Гэвч гүйцэтгэгч угаалгын ванныг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгээгүй, зарим ванныг уруу газар барьсан зэргээс шалтгаалан мал угаах боломжгүй, ашиглагдахгүй байгаа нь уг төсөл үр дүнгүй болсныг илтгэж байна.

Төслийн хөрөнгөөр гүйцэтгэсэн барилга угсралт, төсөл арга хэмжээг чанаргүй, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1⁵, 14.1.2⁶-т заасныг зөрчсөн байна. Иймд барилга угсралтын ажлыг чанаргүй, зураг төслийн дагуу гүйцэтгээгүй дээрх төсөл арга хэмжээг Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁷, 14.6⁸, 40 дүгээр зүйлийн 40.1.8⁹-т заасны дагуу гүйцэтгэгчээр засварлуулсан, зөрчлийг арилгах албан шаардлагыг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч ГХБХБГ-т хүргүүлээ.

Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг 159 малчин өрхийн 95.6 мянган толгой мал, 32.0 мянган га бэлчээрийн усан хангамжийг сайжруулахаар хийгдсэн нь малчдад нэн тэргүүнд шаардлагатай үр өгөөжтэй төсөл, арга хэмжээ болсон байна.

Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумдад “Малчдын мэдээллийн танхим” тохижуулах зорилгоор 30.0 сая төгрөгөөр техник, тоног төхөөрөмж, тавилга, бараа материал бэлтгэх төсөл хэрэгжиж 28.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Төслийн тоног төхөөрөмжийг Түвшинширээ суманд олгоогүй, Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумд өөр зориулалтаар ашиглаж байна.

Бог малын үйлчилгээний зогсоолыг сум бүрд олгосон боловч зарим сум оролцооны мөнгийг шийдвэрлээгүйгээс хөрөнгийг аваагүй, авсан сумд хөрөнгийг огт ашигладаггүй, агуулахад хадгалж байгаа нь төслийн зорилго бодит байдал дээр хэрэгцээ шаардлагатай эсэх нь тодорхойгүй, үр өгөөж багатай арга хэмжээнүүд хэрэгжсэнийг харуулж байна.

БҮЛЭГ2: Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дунд хугацааны бодлогуудтай уялдсан байна.

Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээтэй нийцжээ

Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2021 онд “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийг хэрэгжүүлсэн байна. Төсөл нь дараах зорилгын хүрээнд хэрэгжсэн байна.

Сүхбаатар аймагт НАМЭМ-ийн төслийн хүрээнд бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлсэн нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.5-т тусгасан “Шинжлэх ухааны үндэслэлтэй бэлчээрийн

⁵ зураг төслийн дагуу баригдсан байх;

⁶ барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

⁷ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

⁸ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

⁹ барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах;

менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх замаар аймаг, сумын хэмжээнд нэгж талбайн ашиглалтыг сайжруулах” гэсэн зорилт, арга хэмжээтэй нийцсэн байна.

БОАЖЯ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, хөгжлийн хөтөлбөрийн тусламжаар дараах төслүүд хэрэгжиж байна. Үүнд:

- *Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янзын байдлын хамгаалал;*
- *Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь;*

Дээрх төслүүдээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сүхбаатар аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр” тусгасан зорилт арга хэмжээтэй нийцсэн байна.

Б.2 Гадаадын тусламжаар хөдөө аж ахуйн салбарт 2 төсөл хэрэгжиж байна

Ногоон алт малын эрүүл мэнд төсөлд сонгогдсон 6 сумын бэлчээрийн менежментийн дунд хугацааны /2018-2021/ төлөвлөгөөг Мерси Кор олон улсын байгууллага хамтран боловсруулж ИТХ-аар батлуулсан байна.

НАМЭМ төслийн зохицуулагч УЦУОШГ-ын бэлчээрийн даац, ургацын мэдээний тайланг төсөл хэрэгжихээс өмнөх болон дараах мэдээллийг харьцуулж үзэхэд нэмэгдсэн үр дүн гарсан байна.

Төсөл бүрийн хэрэгжилт, үр өгөөжийг нарийн үнэлж тооцон, үр дүнг хэмжсэн ажлууд дутмаг байна.

Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янзын байдлын хамгаалал төсөл Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт суманд хэрэгжиж байгаа бөгөөд 386.0 сая төгрөгийн тусламж, дэмжлэгийг үзүүлсэн байна.

д/д	Арга хэмжээний нэр	мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	Хонин ноос хяргах цахилгаан машин, пресс	63.2
2	Сүү боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	92.1
3	Цахилгаан саалтуур	13.7
4	Сүүний бидон 40 л	7.3
5	Хурганы тэжээл	84.3
6	Ногоон тэжээлийн үр	4.8
7	Мод үржүүлгийн газарт дэмжлэг	16.8
8	Хүнсний ногооны бүлэгт дэмжлэг	36.3
9	Түмэнцогт сумын зөгийн балын үйлдвэрт дэмжлэг	39.0
10	Сургалтын зардалд	28.5
НИЙТ ДҮН		386.0

Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төслөөр дараах хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байна.

- *Дарьганга, Түвшинширээ суманд булгийн эх хашиж хамгаалахад 15.7 сая;*
- *Баруун –Урт суманд өвс, тэжээлийн саравч, агуулах хашаа барихад 150.0 сая, Уртын голын эхэнд татмын ойжуулалтын хашаа барихад 45.0 сая;*
- *Сумдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргахад 225.0 сая;*
- *Түмэнцогт суманд өвс, тэжээлийн саравч, агуулах хашаа барихад 180.0 сая, Халзан сумын өвс тэжээлийн агуулахыг засварлахад 37.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.*

Дээрх 2 төсөл нь үргэлжлэн хэрэгжиж байгаа тул үр дүн, үр өгөөжийг тооцох боломжгүй байна.

БҮЛЭГЗ: Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөлд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт хийлгэх, нэгдсэн мэдээллийн сантай болох шаардлагатай байна.

В.1 Зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийг иргэд олон нийтэд ил тод мэдээлэх, хяналт тавих ажил хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6¹⁰-д гадаадын зээл, тусламжийн мэдээллийг иргэд олон нийтэд мэдээлэхээр тусгасан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн мэдээллийг shilendans.gov.mn цахим системд байршуулсан эсэхийг тулган үзэхэд дараах төслийн мэдээллийг мэдээлсэн байна.

Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн мэдээллийг цахим системд байршуулсан боловч төсөл арга хэмжээ тус бүрээр мэдээлээгүй нэгдсэн байдлаар мэдээлсэн нь тухайн орон нутагт ямар төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа нь ил тод нээлттэй болоогүй байна.

Иймээс орон нутгийн төрийн захиргааны байгууллага төслийн мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй ил тод хүргэх ажилд хяналт тавьж, төслийн нэгж, зохицуулагчтай хамтран зохион байгуулах шаардлагатай байна.

Зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн БУА-ын төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ГХБХБГ гүйцэтгэжээ.

Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ буюу барилга, угсралтын ажлын гүйцэтгэлд Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ын 2 дугаар зүйлийн 2.9-т заасны дагуу аймгийн ГХБХБГ захиалагчийн техникийн болон үе шатны хяналтыг хэрэгжүүлжээ.

Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бог малын угаалгын ванны ажлын гүйцэтгэлд аймгийн МЭГ-аас хяналт хэрэгжүүлж, гарсан зөрчилд Мал эмнэлгийн улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ, ХХААГ-т орон нутагт хэрэгжиж байгаа төслийн талаарх нэгдсэн мэдээлэл байхгүй байна. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн талаар ТХН болон төрийн захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог хангасан эрх зүйн зохицуулалтгүй байна.

Энэ нь гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөлд орон нутгийн захиргааны байгууллага нэгдсэн мэдээлэлгүй байх, хяналт хэрэгжүүлэх боломжгүйгээс төсөл үр өгөөжгүй болох асуудлууд байна. Иймд Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нэгж болон төрийн захиргааны байгууллагын уялдаа холбоог зохицуулсан эрх зүйн актын нэмэлт өөрчлөлт шаардагдаж байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2¹¹-т заасны дагуу аймгийн Засаг даргын бүрэн эрхэд орон нутагт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга

¹⁰ Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;

¹¹ тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавихыг зохицуулсан боловч хэрэгжилт хангалтгүй, зохицуулалтын орчныг сайжруулах шаардлага байна.

Орон нутгийн төрийн захиргааны байгууллагад гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний мэдээ, мэдээлэл хангалтгүй байгаагаас төслийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа арга хэмжээнд давхардал гарч байна. Үүнд:

1. Баруун-Урт суманд ЗЗБУХ төслийн санхүүжилтээр 2020 онд өвс тэжээлийн саравч, агуулахыг барьж гүйцэтгэсэн бол “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр тус суманд дахин өвс тэжээлийн саравч, агуулах барьсан байна.

Аймгийн ЗДТГ, орон нутгийн захиргааны байгууллага гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг нэгтгэн хяналт тавьж, хөрөнгө оруулалтын зарим эх үүсвэрийг төслийн хөрөнгөөр шийдвэрлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдсэн нэг мэдээллийг эх үүсвэртэй болсноор төсөл үр дүнгүй, үр өгөөжгүй байдаг асуудлыг шийдвэрлэж, эрх зүйн зохицуулалтын орчин сайжрахаар байна.

Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад төслийн нэгжээс хяналт-шинжилгээ үнэлгээ хийгджээ

Гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн үйл ажиллагаа, чиг үүрэг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмын 23¹² дугаар зүйл, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын 24¹³ дүгээр зүйлд зааснаар зохицуулагдаж байгаа тул орон нутгийн хэмжээнд дүгнэлт гаргах боломжгүй байна.

Харин төсөл хэрэгжүүлэх нэгжээс орон нутагт хэрэгжиж байгаа төсөлд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.

В.2 Төслийн санхүүжилтээр хийгдсэн зарим хөрөнгийг бүртгээгүй, төрийн болон орон нутгийн төсвийн байгууллага давхар бүртгэжээ.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хугацаа дууссантай холбогдуулан төслийн зохицуулагчийн ашиглаж байсан 27.6 сая төгрөгийн үнэ бүхий мотоцикл, ширээ сандал, тоног төхөөрөмжийг тухайн сумын ЗДТГ-т хүлээлгэн өгч данс бүртгэлд бүртгэсэн боловч ТӨБЗГ-ын тогтоолоор аймгийн ХХААГ-ын дансанд давхардуулан бүртгүүлсэн байна.

Иймд төслийн санхүүжилтээр хийгдсэн ажлыг данс бүртгэлд тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн давхардлыг арилгах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлсэн.

---o0o---

Дүгнэлт:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

¹² Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

¹³ Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төслийн 29.4 хувь нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа бол бусад төслийн хувьд чанаргүй гүйцэтгэсэн, төрийн байгууллага хуульд заасан шалгуур хангаагүй зээл авсан, хяналтгүй байгаагаас зарим төслийн үр өгөөж үр дүнгүй байна.
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дунд хугацааны бодлогуудтай уялдсан байна.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөлд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт хийлгэх, нэгдсэн мэдээллийн сантай болох шаардлагатай байна.
- Аймгийн ЗДТГ, орон нутгийн захиргааны байгууллага гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт тавих, хөрөнгө оруулалтын зарим эх үүсвэрийг төслийн хөрөнгөөр шийдвэрлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөлд орон нутгийн захиргааны байгууллага нэгдсэн мэдээлэлгүй байх, хяналт хэрэгжүүлэх боломжгүйгээс төсөл үр өгөөжгүй болох асуудлууд байна
- Төслийн зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, давхардуулан бүртгэсэн, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх ажил хангалтгүй хэрэгжиж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг даргад

1. Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Өрийн удирдлагын тухай хуультай нийцүүлэн авч хэрэгжүүлэх,

Санхүү төрийн сангийн хэлтэст

1. Хөдөө аж ахуйг дэмжих санд аймгийн ЗДТГ-тай холбоотой үүссэн өр төлбөрийн тооцоог нийлж, барагдуулах ажлыг зохион байгуулах,

ХХААГ-т

1. Хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, иргэд олон нийтэд мэдээлэх, мөн төслийн зохицуулагчтай хамтран ажиллах,
2. Хөдөө аж ахуйг дэмжих санд ХХААГ-тай холбоотой үүссэн өр төлбөрийн тооцоо нийлж, барагдуулах ажлыг зохион байгуулах,

Аймгийн ОНӨГ-т

1. Зах зээл бэлчээрийн удирдлага төслөөр хэрэгжсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчид давхар бүртгэгдсэн хөрөнгийг холбогдох байгууллагатай хамтран давхардлыг арилгаж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах,

Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал

1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн нэгж болон төрийн захиргааны байгууллагын уялдаа холбоог зохицуулсан эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлага байгааг уг аудитаар уламжлах.
2. Төслийн зээл, тусламжид хамрагдаж байгаа иргэн аж ахуйн нэгж байгууллага нэг төслөөр олон зээлийн эх үүсвэрт хамрагдаж, бусдын төсөл хэрэгжүүлэх боломжийг хаах, зээлээ эргэн төлөхгүй болох эрсдэлүүд үүсэж байгаа учир зээлийн мэдээллийн сангуудыг нэгтгэн удирдаж, давхардал үүсэх асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг уламжлах.

---o0o---

